

“МОНГОЛ КООСЭН” ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН БАГШ, АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. “Монгол Коосэн” Технологийн коллеж /цаашид сургууль гэх/ нь өөрийн үнэт зүйл, эрхэм зорилгод нийцүүлэн сургалт, эрдэм шинжилгээ, нийгмийн хариуцлагын үүргээ биелүүлэхийн тулд нийтлэг үнэт зүйл, хэм хэмжээ, ёс суртахууны зарчмыг мөрдлөг болгоно.
- 1.2. Сургуулийн багш, ажилтны дагаж мөрдөх ёс суртахууны зарчим, хэм хэмжээг тогтоон, хэвшүүлэн сахиулах, мэргэжлийн нэр төрийг нь хамгаалах, ёс суртахууны зөрчлийн тухай мэдээлэл, гомдол гаргах, түүнийг хүлээн авах, шалган шийдвэрлэх, зөрчил гаргасан этгээдэд сахилгын шийтгэл хүлээлгэхэд энэхүү дүрмийн зорилго оршино.
- 1.3. Багш, ажилтны ёс зүйн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Захирлын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэж, захирлын тушаалаар баталгаажуулна.

Хоёр. Нэр томьёо

- 2.1. “Багш, ажилтны мэргэжлийн ёс зүй” гэж багш ажилтны ажил, мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой нийтээр хүлээн зөвшөөрсөн итгэл үнэмшил, хэвшсэн соёл болон харилцааны үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.
- 2.2. “Монгол Коосэн” Технологийн коллежийн багш гэж тус сургуулийн профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багшийн зэрэгтэй багш нарыг хамааруулна.
- 2.3. “Монгол Коосэн” Технологийн коллежийн удирдах ажилтан гэж бүх шатны шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан, тухайлбал, сургуулийн захирал, дэд захирал, сургалтын менежер, тэнхим, лаборатори, төвийн эрхлэгч, захиргаа, санхүү, аж ахуйн асуудал хариуцсан нэгжийн удирдах ажилтныг хэлнэ.
- 2.4. “Монгол Коосэн” Технологийн коллежийн ажилтан гэдэгт сургуулийн захиргааны болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн, эрдэм шинжилгээ, гадаад харилцаа, аж ахуй, төв, оюутны бие даан суралцах төв, тэнхим, лабораторийн ажилтан, туслах ажилтан, ажилчин хамаарна.
- 2.5. “Ашиг сонирхлын зөрчил” гэж тус сургуулийн гишүүн аливаа үйл ажиллагаандаа амин хувийн болон эдийн засгийн ашиг олох үүднээс “Монгол Коосэн” Технологийн коллежид материаллаг ба материаллаг бус хохирол учруулахуйц нөхцөл байдал үүсгэхийг ойлгоно.
- 2.6. “Зөрчил” гэж энэхүү дүрмийн заалтыг зөрчсөн “Монгол Коосэн” Технологийн коллежийн гишүүний үйлдэл, эс үйлдлийг ойлгоно.
- 2.7. “Гомдол” гэж зөрчлийн улмаас хохирсон гэж үзэн “Монгол Коосэн” Технологийн коллежийн гишүүн эсхүл түүний төлөөллөөс эрх бүхий байгууллагад зохих журмын дагуу хандаж, уг хохирлыг арилгуулахаар бичгээр гаргасан хүсэлт байна.
- 2.8. “Ёс зүйн зөвлөл” гэж багш, ажилтан, оюутны ёс зүйн асуудлаар үйл ажиллагаа зохион байгуулж, зөвлөмж, дүгнэлт гаргах эрх үүрэг бүхий сургуулийн орон тооны бус нэгж байна.
- 2.9. “Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэж ёс зүйн зөрчилтэй холбогдуулан гаргасан санал гомдлыг холбогдох дүрэм, журмын дагуу шийдвэрлэх явц юм.

Гурав. Дүрмийн үйлчлэх хүрээ

3.1. Сургуулийн нийт багш, ажилтан энэхүү Ёс зүйн дүрмийг даган биелүүлж, түүнд захирагдана.

3.2. Сургуулиас зохион байгуулж буй аливаа ажил, үйл ажиллагааны явцад энэхүү ёс зүйн дүрэм хэрэгжинэ.

3.3. “Монгол Коосэн” Технологийн коллежтой гэрээгээр ажиллаж буй аливаа бусад байгууллагын ажилтан гэрээнд заасны дагуу ажил үүрэг гүйцэтгэхдээ энэхүү дүрмийг мөрдөх бөгөөд зөрчил гаргасан тохиолдолд үндсэн байгууллагад нь албан ёсоор мэдэгдэнэ.

Дөрөв. Багш, ажилтны эрх

4.1. Сургууль нь багш, ажилтны сургалт, судалгаа явуулах, ажиллах хэвийн нөхцөлөөр хангах үүрэгтэй.

4.2. Сургууль нь дүрмээрээ багш, ажилтны сургалт, судалгаа явуулах болон ажиллах эрх чөлөөг хамгаална.

4.3. Багш, ажилтан нь Монгол улсын үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан эрхээр хангагдана.

Тав. Багш, ажилтны ёс зүйн хэм хэмжээ

5.1. Багшлах үүргээ хэрэгжүүлэх ёс зүйн хэм хэмжээ

5.1.1 Багш оюутандаа бүтээлчээр бие даан суралцах чадвар эзэмшүүлэхэд анхаарч, суралцах үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.

5.1.2. Багш оюутанд хувь хүнийх нь хувьд хүндэтгэлтэй хандаж, тэдний сурах үйл ажиллагааг удирдан чиглүүлэгч, зөвлөгч нь байна.

5.1.3. Багш, оюутны хоорондын харилцаанд харилцан хүндэтгэлийг эрхэмлэнэ.

5.1.4. Багш оюутны мэдлэг, чадвар, хүчин чармайлтыг бодитой, шударга үнэлдэг байна.

5.1.5. Багш нь оюутны сургалтын ажил, сахилга бат, соёлч боловсон байдал, хүмүүжил, үндэсний уламжлал, ёс суртахууны төлөвшлийн асуудлаар зөвлөн ажиллана.

5.1.6. Багш хичээлийн стандартыг агуулгын болон арга зүйн өндөр түвшинд хэрэгжүүлнэ.

5.2. Багшийн мэдлэг, боловсролд тавих ёс зүйн хэм хэмжээ

5.2.1. Багш нь өөрийн мэдлэг, боловсрол, заах арга зүй, судалгаа шинжилгээ хийх ур чадвараа тасралтгүй дээшлүүлж ажиллана.

5.2.2. Багш хамтран ажиллагч багш нартайгаа өөрийн мэдлэг, туршлагыг хуваалцан, бусдаас мэргэжлийн хувьд суралцахыг эрмэлзэнэ.

5.3. Сургалтын байгууллагын багш, удирдах ажилтан, ажилтны ёс зүйн хэм хэмжээ

5.3.1. Багш, удирдах ажилтан, ажилтан нь бүтээлч, санаачилгатай, шударга ажиллаж, ажил үүргээ мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх;

5.3.2. Багш, удирдах ажилтан, ажилтан нь сургуулийн дүрэм, хөдөлмөрийн дотоод журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, сургалт хүмүүжил, судалгааны ажлын хөтөлбөрийн хэрэгжилтэд саад учруулахгүй байхыг ухамсарлан, өвдөх, түр чөлөө авах, ажлаас гарах зэрэг тохиолдлыг холбогдох албан тушаалтанд урьдчилан мэдэгдэх;

5.3.3. Бүх ажилтан ажлын цагийг баримталж, өглөөний шуурхай уулзалтад оролцож, цахим шуудан, захиагаа тогтмол шалгах;

5.3.4. Байгууллага болон хувь хүний нууцыг чандлан хадгална;

5.3.5. Удирдах ажилтан нь сургууль, нэгжийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, бодлого боловсруулах чадвартай байж, түүний хэрэгжилт, явц, үр дүнд анхаарч ажиллах;

5.3.6. Удирдах ажилтан өөрийн удирдах арга барил, хууль эрх зүй, менежментийн мэдлэг, чадвараа байнга дээшлүүлж, сургуулийн хөгжил цэцэглэлтэд бодитой хувь нэмэр оруулах;

5.3.7. Удирдах ажилтан боловсролын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд идэвх санаачилгатай, бүтээлч, хариуцлагатай оролцох;

5.3.8. Удирдах ажилтан нь сургуулийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хамт олонд ил тод, нээлттэй байлгах;

5.3.9. Удирдах ажилтан аливаа шийдвэрийг сургууль, хамт олны эрх ашгийн үүднээс ухаалаг, зүй зохистой, үндэслэлтэй гаргах, шийдвэрийн үр дүнд хяналт тавих.

5.4. Хамт олон, оюутан суралцагчтай харилцахад баримтлах ёс зүйн хэм хэмжээ

5.4.1. Багш, ажилтан нь хамт олон, оюутан суралцагч, тэдний эцэг, эх, асран хамгаалагчтай хүндэтгэлтэй харилцаж, ажил төрлийн холбогдолтой бодит шүүмжлэл, саналыг хүлээн авч, санал нийлэхгүй зөрчилтэй байдлыг эв зүйгээр шийднэ.

5.4.2. Багш, ажилтан нь хамт олныхоо сургалт, хүмүүжлийн ажлыг бүтээлчээр явуулах, хөдөлмөрлөх, судалгаа шинжилгээ хийх эрх чөлөөг хүндэлнэ.

5.4.3. Багш, ажилтан нь санал солилцох, шүүмжлэл илэрхийлэхдээ бусад хүмүүсийн үзэл бодолд хүндэтгэлтэй хандана.

5.4.4. Багш, ажилтан нь үүргээ ухамсарлан хамт ажиллаж байгаа багш, ажилтны талаар мэргэжлийн дүгнэлт өгөхдөө бодитой хандана.

5.5. Эцэг, эх, олон нийт

5.5.1. Боловсролын байгууллагаар үйлчлүүлэгчид багш, ажилтны нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн үзэх;

5.5.2. Багш хууль тогтоомжоор заасан ажил үүргээ гүйцэтгэх үйл явцыг санаатай болон санамсаргүйгээр тасалдуулахгүй байх.

6.1. Багшлах үйл ажиллагаанд

Багшлах үүргээ биелүүлэхгүй байх:

- 6.1.1. Багш нь өөрийн үзэмжээр оюутныг хичээлд оруулахгүй байх;
- 6.1.2. Багш нь хичээлд холбогдолгүй материалыг сургалтад ихээр ашиглах;
- 6.1.3. Багш нь хичээл, шалгалт болон ажлын цагийн хуваарийг зохицуулсан дүрэм, журмыг зөрчих;
- 6.1.4. Багш нь суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг тухайн хичээлд шууд хамааралгүй шалгуураар дүгнэх;
- 6.1.5. Суралцагчийн сургалтын үр дүнг үнэлэх ажлыг шалтгаангүйгээр буюу тодорхойгүй хугацаагаар дур мэдэн хойшлуулах;
- 6.1.6. Хичээлийн цагийг үр бүтээлгүй өнгөрөөх, эрт завсарлуулах.
- 6.1.7. Багш нь оюутны дүнг засах, хувийн хэрэг, журнал, боловсролын гэрчилгээ зэрэг албан бичигт санаатайгаар буруу бичилт хийх, хуурамчаар үйлдэх, устгах;
- 6.1.8. Багш нь өөрийн болон бусдын бичсэн ном, сурах бичгийг суралцагчдад тулган зарж, борлуулах;
- 6.1.9. Багш нь суралцагчдыг үндэс угсаа, хэл соёл, нас, хүйс, арьс өнгө, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, эрүүл мэндийн онцлог шинжээр ялгаварлан гадуурхах;
- 6.1.10. Багш нь багшлах эрхээ хэрэгжүүлсэний төлөө бусдаас шан харамж авах.

6.2. Багшийн мэдлэг, боловсрол, чадварын хувьд

- 6.2.1. Багш хичээллийн хөтөлбөрийг стандартын дагуу боловсруулж, сайжруулах ажлыг хангалтгүй хийх;
- 6.2.2. Бусдын зохиол, бүтээл, нийтлэл, судалгааны ажлыг санаатайгаар, хууль бусаар өөрийн болгох.

6.3. Сургалтын байгууллагын багш, удирдах ажилтан, ажилтны хувьд

- 6.3.1. Сургуулиас зохион байгуулсан, санаачилсан ажил, үйл ажиллагаанд санаатай саад учруулах;
- 6.3.2. Сургуулийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг зөвшөөрөлгүй хувийн болон арилжаа, улс төр, шашны зорилгоор ашиглах;
- 6.3.3. Ажлын цагаар ажлын холбогдолгүй хувийн ажил хийх;
- 6.3.4. Сургуулийн бусад багш, ажилтныг ажил үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулах, заналхийлэх, дарамтлах, албан өрөөнд их дуу чимээ гаргаж, бүдүүлэг аашлах;
- 6.3.5. Ажлын цагаар албан ёсны чөлөө авалгүй хувийн асуудал хөөцөлдөх;
- 6.3.6. Хичээлийн байранд согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэх, ажилдаа согтуу ирэх;
- 6.3.7. Суралцагчдад зөв үлгэр дуурайлал үзүүлэлгүй зориулалтын бус, хориглосон газарт тамхи татах;
- 6.3.8. Хувийн үзэл бодлоо санаатайгаар сургууль, түүний нэгжийн байр суурь хэмээн ойлгуулах;
- 6.3.9. Багш, ажилтан ил задгай, зохисгүй хувцаслах;
- 6.3.10. Хамт олны дотор хов жив ярих, худал мэдээлэл тараах;
- 6.3.11. Оюутан, тэдний эцэг эх, бусдын дэргэд маргалдах, хэрүүл хийх;

6.3.12. Багш, ажилтан нь бусдын гарын үсгийг хуурамчаар дуурайлган ашиглах, тамга тэмдэг ашиглах, дарж баталгаажуулах;

6.3.13. Багш, ажилтан нь оюутан суралцагч, тэдний эцэг эх, асран хамгаалагч, хамтран ажилладаг байгууллага, хувь хүнээс хууль бус, сургуулийн дүрэм, журамд тусгагдаагүй, тушаал шийдвэрээр баталгаажаагүй төлбөр, хураамж, хандив авахгүй байх;

6.3.14. Томилолтын тогтоосон хугацааг дур мэдэн хэтрүүлэх;

6.3.15. Багш, ажилтан нь өвдөх, түр чөлөө авах, ажлаас гарах зэрэг тохиолдолд сургуулийн дүрэм, хөдөлмөрийн дотоод журмын дагуу холбогдох албан тушаалтанд урьдчилан мэдэгдэхгүй байх, сургуулийн үйл ажиллагаанд саад учруулах;

6.3.16. Хамт ажиллагсад, оюутан сурагчдыг садар самуунд уруу татах, бэлгийн дарамт үзүүлэх;

6.3.17. Оюутан суралцагчийг биеийн болон сэтгэл санааны дарамтад оруулах.

6.4. Сургалтын байгууллагын удирдах ажилтны хувьд

6.4.1. Албан тушаалаа урвуулан ашиглах;

6.4.2. Бусдад ажлын байрны дарамт үзүүлэх;

6.4.3. Аливаа тендер, сонгон шалгаруулалт, худалдах, худалдан авах, боловсон хүчнийг сонгох, дэвшүүлэх зэрэгт өөрийн хамаатан садан, хувийн ойр дотно харилцаатай найз нөхдийг дэмжих, ашиг сонирхлын зөрчил гаргах;

6.4.4. Боловсон хүчнийг ажилд авах, албан тушаалд дэвшүүлэх, ажилд томилох, шагнал урамшуулалд тодорхойлох, мэргэжил дээшлүүлэхэд ашиг сонирхлын зөрчил гаргах, ил тод байдлыг үл хангах;

6.4.5. Багш, ажилтан, суралцагчдыг үндэс угсаа, хэл соёл, нас, хүйс, арьс өнгө, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, эрүүл мэндийн онцлог шинжээр ялгаварлан гадуурхах.

Долоо. Багш, ажилтны ёс зүйн зөрчил гаргагчдад хүлээлгэх хариуцлага

7.1. “Монгол Коосэн” Технологийн коллежийн нийт багш, ажилтан, оюутан бүр ёс зүйн зөрчил гарсан даруйд нь таслан зогсоох, зүй ёсны шаардлага тавих, Ёс зүйн зөвлөлд хандан ёс зүйн зохисгүй үйлдлийн талаар мэдээллэх үүрэгтэй.

7.2. Багш, ажилтан ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд түүнд холбогдох хууль тогтоомж, сургуулийн хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ болон энэхүү Багш, ажилтны ёс зүйн дүрэмд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

7.3. Багш, ажилтны ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн багш, ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг “Монгол Коосэн” Технологийн коллежийн Ёс зүйн зөвлөлөөр хэлэлцэж, саналаа эрх бүхий албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлнэ.

7.4. “Багш, ажилтны ёс зүйн дүрэм”-ийн заалтуудыг зөрчсөн багшид Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, “Багшлах эрх олгох, хасах журам”, “Багшид мэргэжлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам”-ын дагуу хариуцлага хүлээлгэх ба энэ талаарх заалтыг байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд тусгана.

7.5. Ёс зүйн зөрчил гаргасан багшид хүлээлгэх хариуцлага нь нийгэм, байгууллага, багш, ажилтан, оюутанд учруулсан хор хохиролд нь тохирсон байна.

- 7.6. Ёс зүйн зөрчил гаргасан эсэх асуудлыг Ёс зүйн зөвлөл хянан шийдвэрлэх бөгөөд зөрчил гаргасан багш, ажилтанд зөрчлийн хэм хэмжээ, нөхцөл байдал, тогтоогдсон байдал, нийтэд илэрхий байдлыг харгалзан сургуулийн захирал тушаал гаргаж, дараах сахилгын шийтгэлийг ногдуулна. Үүнд:
- 7.6.1. Амаар болон бичгээр сануулах;
 - 7.6.2. Үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хувиар бууруулах;
 - 7.6.3. Ажлаас халах.
- 7.7. Сануулах сахилгын шийтгэлийг анх удаа зөрчил гаргасан буюу зөрчлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан ажилтанд ногдуулж, ажилтны буруугаас сургуульд эд хөрөнгийн хохирол учирсан бол хохирлыг нөхөн төлүүлэх, ёс зүйн зөрчлийг удаа дараа гаргасан, хуулийн байгууллагаар зөрчил, гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон бол ажлаас халах хүртэл сахилгын шийтгэл ногдуулна.
- 7.8. Багш, ажилтны хувьд энэхүү дүрэмд заасан ёс зүйн зөрчил гэж үзсэн үйлдлүүдийг мэдээгүй байсан нь хариуцлага хүлээлгэхгүй байх үндэслэл болохгүй.
- 7.9. Сургуулийн хөдөлмөрийн дотоод журам, багш, ажилтны ёс зүйн дүрмийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй зөрчлийг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Найм. Бусад зүйл

- 8.1. Ёс зүйн зөвлөл нь ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн багш, ажилтны тухай мэдээллийг хүлээн авч, баримтжуулан шалгах бөгөөд ёс зүйн зөвлөлийн ажиллах журамд зааснаар сахилгын шийтгэл, хариуцлага ногдуулах эсэх саналаа сургуулийн захирлын дэргэдэх зөвлөл, холбогдох дээд байгууллагад тавьж, шийдвэрлүүлнэ.

-00o00-